Цэвэрлэх байгууламжийн технологи нь олон улсад бүрэн туршигдсан, өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд Монгол орны цаг уурын нөхцөл байдалд тохируулсан А/О биореактортой технологийг ашиглан бохир усыг гүн цэвэрлэж цэвэрлэсэн усны чанар стандартын шаардлагад нийцүүлэх тул технологийн зориулалтаар дахин ашиглах боломжтой. Цэвэрлэх байгууламжид үүсэх илүүдэл лагийг зураг төсөлд тусгагдсан зохих технологийн дагуу усгүйжүүлэн байгалийн шохойтой хольж боловсруулан тогтвортой бүтээгдэхүүн гарган авч, ногоон байгууламжид, газрын нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой.

#### **Зорилт 2 Бохир усны цэвэрлэгээнд шинжилгээ хийх лабораторитой болно.**

Цэвэрлэх байгууламжийн бохир усны цэвэрлэгээний чанар, технологийн горимын үр ашгийг үнэлэх зорилгоор орох болон гарах усны дээжид Монгол Улсын стандарт (MNS) болон олон улсын аргачлалын дагуу лабораторийн шинжилгээг гүйцэтгэнэ.

#### **Зорилт 3 НААБ-ыг чадвахжуулж, хүний нөөцийг бэхжүүлнэ.**

Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын нийтийн ах ахуйн үйлчилгээний байгууллагын инженер, техникийн ажилтнууд, лаборантуудад АО технологийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг Монгол орны уур амьсгал, цаг агаарын нөхцөлд тохируулан нутагшуулна.

#### **Зорилт 4 Бохир ус цэвэрлэгээний түвшин сайжирч, байгаль орчны тэнцвэртэй байдал хадгалагдаж, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах, хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.**

Цэвэрлэсэн усны чанарт тавигдах стандартын шаардлагад нийцүүлэн орчин үеийн шинэ техник технологийг ашиглан, хөрс, ус, агаар, хүний амьдрах орчинд аюулгүй байхаар цэвэрлэх байгууламжуудыг төлөвлөн, барилга угсралт, туршилт тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгэж Монгол Улсад мөрдөгдөж буй цэвэрлэх байгууламжийн Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024 стандартын шаардлагад нийцсэн ус хүлээн авч Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан цэвэрлэсэн усыг байгальд нийлүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төслийн удирдах хороо, төсөл хэрэгжүүлэгч нэгж нь “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” тухай Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр журамд заасны дагуу төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, үнэлэхтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын гаргасан тушаал шийдвэр, болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 8, 12, 14, 16, 28, 57, 68 дугаар зүйлүүдэд 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралт “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” 21 дүгээр бүлэг Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсөл нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,593.1 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	39,158,823.6	47,801,182.5	8,642,358.9
Үндсэн хөрөнгө	101,026.2	34,546.4	(66,479.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39,259,849.8</b>	<b>47,835,728.9</b>	<b>8,575,879.1</b>
Богино хугацаат өр төлбөр	112.5	8,917.7	8,805.2
Хуримтлагдсан үр дүн	39,259,737.3	47,826,811.2	8,567,073.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>39,259,849.8</b>	<b>47,835,728.9</b>	<b>8,575,879.1</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс урьдчилгаа, богино хугацаат өр төлбөр болон хуримтлагдсан үр дүнгийн дансдуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 47,801,182.5 мянган төгрөг болж 8,642,358.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд урьдчилж төлсөн шатахуун болон даатгалын төлбөрийг зардал болгож, Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудад баригдаж буй ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын төлбөр гарсан;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 8,917.7 мянган төгрөг болж, 8,805.2 мянган төгрөгөөр өссөн нь аудитын төлбөр болон бусад байгууллагад өгөх өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой;
- 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 17,832,637.7 мянган төгрөг буюу 67.3 хувиар буурсан нь төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Дорнод аймгаас бусад аймгийн барилгын ажил дуусаж, үлдэгдэл санхүүжилт гарсан байна.

Төсөл нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “ACOLOUS” төсөвт байгууллагын санхүүгийн программыг ашигладаг бөгөөд тайлант онд программ хангамжтай холбоотой зардал гаргаагүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төслийн нэгж нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлийн санхүүжилтээс 21,874,287.8 мянган төгрөг, улсын төсвөөс урсгал зардлыг 790,107.5 мянган төгрөг, нийт зарлагыг 22,664,395.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төслийн нэгжийн төсвийн саналыг Сангийн яамнаас урсгал зардлыг 499.0 мянган төгрөгөөр, гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлыг 11,476,889.7 мянган төгрөгөөр бууруулж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 11,187,006.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгийн зардлын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй

буюу 2025 оны барилгын ажлын санхүүжилтийн хуваарьтай холбоотой хөрөнгийн зардлын хэмжээг бууруулан баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 4,734,928.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 782,893.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 119,632.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн ба 663,261.0 мянган төгрөгийг зарцуулсан. Гадаад зээлийн санхүүжилтээс 8,254,368.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,762,110.7 мянган төгрөг буюу 67.6 хувьтай байгаа нь гадаад эх үүсвэрээр зарцуулах хөрөнгийн зардал 5,033,476.7 мянган төгрөг, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 110,082.3 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 5,205.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 2,982.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 7,307.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын болон бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 770.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл	15,921,934.9	10,762,110.7	5,159,824.2	67.6
1.1	80104 Зээлийн зарцуулалт	10,400,000.0	8,254,368.9	2,145,631.1	79.4
1.2	83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал	789,608.5	663,261.0	126,347.5	84.0
1.3	83112 Төслийн хүрээний гаалийн татвар болон НӨАТ	4,732,326.4	1,844,480.8	2,887,845.6	39.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Нэгдсэн судалгааны үр дүнгийн талаар:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Уг төсөл хэрэгжүүлэгч нэгжийг Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц орон тоог батлах тухай” 174 дүгээр тушаалын дагуу Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлж, ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон.
2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтнуудад унаа, хоолны хөнгөлөлт олгоогүй, зөвхөн үндсэн цалингийн зардал гарсан байна.
3. Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээтэй холбоотой зардал гараагүй байна.
4. Тайлант онд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг зохион байгуулаагүй, үүнтэй холбоотой зардал гаргаагүй байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, холбогдох задал гараагүй байна.

6. Тайлант хугацаанд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд Баян-Өлгий аймаг /4200м<sup>3</sup>/хоног/, Говьсүмбэр аймаг /2000м<sup>3</sup>/хоног/, Завхан аймаг /3000м<sup>3</sup>/хоног, Увс аймаг /3000м<sup>3</sup>/хоног/, Дорнод аймаг /5000м<sup>3</sup>/хоног/ хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барих төслийн хүрээнд нийт 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Баян-Өлгий, Өлгий сум/	2021-2025	Бохир ус цэвэрлэх байгууламжууд орчин үеийн дэвшилтэд техник технологид шилжинэ. Цэвэрлэх байгууламжийн технологи нь олон улсад бүрэн туршигдсан, өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд Монгол орны цаг уурын нөхцөл байдалд тохируулсан А/О биореактортой технологийг ашиглан бохир усыг гүн цэвэрлэж цэвэрлэсэн усны чанар стандартын шаардлагад нийцүүлэх тул технологийн зориулалтаар дахин ашиглах боломжтой. Цэвэрлэх байгууламжид үүсэх илүүдэл лагийг зураг төсөлд тусгагдсан зохих технологийн дагуу усгүйжүүлэн байгалийн	97.67%	14,833,466.9	10,905,558.8
2	Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2021-2025		97.11%	14,010,261.7	10,164,432.6
3	Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Завхан, Улиастай сум/	2021-2025		97.04%	16,325,976.0	12,032,467.8
4	Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Увс, Улаангом сум/	2021-2025		96.27%	15,904,763.0	11,618,693.0
5	Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Дорнод, Хэрлэн сум/	2021-2025		33.33%	13,389,130.6	3,081,592.8

			шохойтой хольж боловсруулан тогтвортой бүтээгдэхүүн гарган авч, ногоон байгууламжид, газрын нөхөн сэргээлтэд ашиглах боломжтой юм.			
<b>НИЙТ</b>				<b>84.28%</b>	<b>74,463,598.2</b>	<b>47,802,745.0</b>

Дээрхи 5 аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийн явц Дорнод аймгийн Хэрлэн сумаас бусад аймгуудад бүрэн хэрэгжсэн. Харин Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах бохир ус цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл 33.33 хувьтай байна. Ерөнхий гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Польш Улсын “МЕЛИОРЕКС” ХХК сонгогдож, 2021 оны 07 дугаар сарын 13-ны өдөр 2021/220 дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 5,000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барих ажлын хүрээнд хийсэн боловч БХБЯ-ны 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 2022/39 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгавараар 10,000м3/хоног хүчин чадалтай болгохоор дахин баталсан.

Барилга хөгжлийн төвийн 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 0982/2025 дугаартай барилга байгууламжийн зураг төслийн магадлалын нэгдсэн дүгнэлтийн нэгтгэлээр Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах 10,000 м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамж болон ариутгах татуургын зураг, төсөв батлагдаж, 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 1551/2025 дугаартай Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр ажлын зураг, төсөв батлагдсан байна.

Дорнод аймгийн 10,000 м3/хон хүчин чадалтай бүрэн автомат бохир ус цэвэрлэх байгууламжийн хувьд 3.2 сая еврогийн үнийн дүнтэй гэрээгээр эхний ээлжинд цаашид өргөтгөх боломжтойгоор 5000м3/хон зөвхөн биологи цэвэрлэгээний байгууламж, насос, тоног төхөөрөмжүүд, 60 метр гүний худгийн ажлуудыг хийхээр ажлын тоо хэмжээнд тусгагдсан. Цаашид бүрэн ашиглалтад оруулахтай холбогдуулан бохир ус цуглуулах систем, илүүдэл лагийн сан, гадна цахилгаан ба гүний худаг гэрэлтүүлэг, дотор холбоо, автомат угсралтын ажил, туршилт тохируулгыг зохион байгуулахад 7.8 сая еврогийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн үлдэгдэл хөрөнгөөр шийдвэрлэхээр “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 113 дугаар тогтоолоор “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төслийн төсөвт өртгийг Дорнод аймгийн Чойбалсан сум 10,998.0 мянган.евроогоор өөрчлөн тогтоосон.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын Сангийн яамны 2025 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн 02/7153 тоот албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны 01/1074, 01/1831 тоот албан бичгүүд, БНПУ-ын Сангийн яамны 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн DG5.9300.46.2025 тоот албан бичгийг үндэслэн Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар батлагдсан “Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам”-ын 2.5-д заасны дагуу БНПУ-ын зээлээр хэрэгжиж байгаа “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хүрээнд гүйцэтгэх “Увс аймгийн Улаангом суманд хийгдэх гадна ариутгах татуургын төв шугам, бохир усны насос станц, аваарын сан, биоцөөрөм шинээр барих

ажил"-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулсан бөгөөд тендерт материал ирүүлсэн оролцогч байгаагүй тул амжилтгүй болсон.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн санхүүгийн тайланд хийх залруулга болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Сүлд-Аудит” ХХК-ийн аудитор Г.Төрсайхан, туслах аудитор Б.Баттогтох нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,193,558.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 61,935.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гадаад томилолт болон багаж тоног төхөөрөмж худалдан авах хэрэгцээ шаардлага байгаа боловч тэвчиж болох зардал хэмээн үзэж илүү зардал гаргаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,815,129.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 1,737,206.7 мянган төгрөгийн 23 мэдээлэл, орлогын гүйлгээнээс 2,077,922.6 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 2024 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газрын түүвэрт хамруулж шалгагдсан ба зөрчилгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах 10,000м<sup>3</sup>/хон хүчин чадалтай ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн гэрээний хэрэгжилт, ажлын явцыг хянах, газар дээрх биет шалгалт хийх

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 458,444.4 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн баталгаагаар тайлант жилийн орлого, зарлагын гүйлгээ нь ерөнхий журналын дүнгээс 151,444.4 мянган төгрөгөөр дутуу байгаа нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27 дугаар параграф, санхүүгийн тайлангийн иж бүрэн болон үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Төрийн сангийн харилцахаар орж ирсэн Захиалагчийн хяналтын төлбөр 307,000.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27 дугаар параграф, санхүүгийн тайлангийн иж бүрэн болон толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
										Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн баталгаагаар тайлант жилийн орлого, зарлагын гүйлгээ нь ерөнхий журналаарх дүнгээс 151,444.4 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	151,444.4	1	151,444.4			1			151,444.4				
2	Төрийн сангийн харилцахаар орж ирсэн Захиалагчийн хяналтын төлбөр 307,000.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй	1	307,000.0	1	307,000.0			1			307,000.0				
	Дүн	2	458,444.4	2	458,444.4			2			458,444.4				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хариуцлага тооцох албан шаардлага		Тоо	Дүн
					Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 1,737,206.7 мянган төгрөгийн 23 мэдээлэл, орлогын гүйлгээнээс 2,077,922.6 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус тайлагнаагүй.	1	3,815,129.3					1	3,815,129.3
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,815,129.3</b>					<b>1</b>	<b>3,815,129.3</b>